

СОЁМБОМЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

Д.Ганзориг: ЭНЭХҮҮ ШАГНАЛ ЦААШИД ХИЙХ АЖИЛД ТАНЬ ТАШУУР БОЛНО ГЭДЭГТ ИТГЭЛТЭЙ БАЙНА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Хөдөлмөрийн баатар болон Гавьяат цол хүртсэн алба хаагчдыг өчигдөр ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг болон даргын зөвлөлийн гишүүд хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Тодруулбал, Хөдөлмөрийн баатар цолоор Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга, дэд хурандаа Д.Жаргалсайхан, Гавьяат барилгачин цолоор Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийн захирагч, хошууч генерал П.Доржсүрэн, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын орлогч дарга, хурандаа Ц.Ганхөлөг, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын ахлах мэргэжилтэн, хурандаа Б.Энхбаяр, Гавьяат тээвэрчин цолоор Зэвсэгт хүчний 7780 дугаар ангийн ачаа тээврийн бүлгийн жолооч, сургагч ахлагч Б.Мөнхтөр, Сүхбаатарын одонгоор Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга асан, бригадын генерал М.Хүрлээ нар шагнагдсан юм.

Тэдэнд хандан ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг



"Эх орныхоо стратегийн өндөр ач холбогдолтой төмөр замыг бүтээн байгуулахад Зэвсэгт хүчний алба

хаагчдаа богино хугацаанд удирдан чиглүүлж, их ажлын ард амжилттай гарсан явдалд дахин талархаж байна.

Энэхүү шагнал та бүгдийн хийснээс илүү цаашид хийх ажилд тань ташуур болно гэдэгт итгэлтэй байна" гэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 4	☁️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	☁️ 22

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 19

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.438.00	3.498.00
CNY 🇨🇳	444.00	447.40
RUB 🇷🇺	38.50	40.20
JPY 🇯🇵	25.73	26.22
KRW 🇰🇷	2.48	2.61

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 28
2021.06.08.
/МЯГМАР ГАРАГ/

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН
МОГОЙ САРЫН ХОЁР ХАР
УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ.

Наран ургах, шингэх:
04.54-20.49

Барилдлага:

Арвидах

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Суудал:

Хий

Ардын тооллын 6 сарын 8, Ангарга гараг. Билгийн тооллын 28, Нэгэн эхийн зургаан хөвүүн одтой, улаагчин гахай өдөр. Өдрийн наран 4 цаг 54 минутад мандан, 20 цаг 49 минутад жаргана. тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатагах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, хараал, жатхыг буцаах, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одоосод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ШАГНАЛ ГАРДУУЛАВ

Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн "Шинэ төмөр зам" төслийн бүтээн байгуулалтад үүрэг гүйцэтгэсэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын офицер, ахлагч, ажилтан албан хаагч болоод төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын зарим бүрэлдэхүүнд Төрийн одон, медаль гардуулах ёслолын ажиллагаа өчигдөр ЗХЖШ-т болов. Шагналыг ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг болон ЗХЖШ-ын даргын зөвлөлийн гишүүд гардуулсан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Б.Энхбаяр, ЗХЖШ-ын БСТГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа М.Батболд, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн захирагч, хурандаа Ц.Батсайхан нар, Цэргийн гавьяаны одонгоор Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Д.Баасансүрэн, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Дорждэрэм нар, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор "Гангүүр" ХХК-ийн ерөнхий захирал Б.Гантөмөр, "Өвөр залаат" ХХК-



ийн дэд захирал Ц.Бат-Эрдэнэ нар, "Алтан гадас" одонгоор Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Б.Хаш-Эрдэнэ, "Туулын гүүр далай" ХХК-ийн ерөнхий захирал Э.Баярчулуун, "Өвөр залаат" ХХК-ийн ерөнхий захирал Ц.Ганцэцэг, "Баткубик" ХХК-ийн ерөнхий захирал Д.Батбаяр нар шагнагдлаа.

Мөн "Цэргийн хүндэт медаль"-аар Зэвсэгт хүчний 7782 дугаар ангийн хийц угсрах мужаан, дэслэгч Э.Энх-Оргил, өөрөө буулгагчийн жолооч, ахлах ахлагч Х.Энхнасан,

ахлах ахлагч Д.Батболд, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн харуулчин О.Эрдэнэямба нар, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Инженерийн дэд бүтцийн хэлтсийн тоо хэмжээний инженер Ж.Чүлтэмнамдаг, Г.Хулан, Зэвсэгт хүчний 7782 дугаар ангийн нягтлан бодогч Д.Алтантуяа нарыг шагнасан юм.

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг төрийн одон, медаль хүртсэн бүрэлдэхүүнд баяр хүргэж хэлсэн үгэндээ "Юуны өмнө

Та бүхэнд хийсэн хөдөлмөрөө төр засгаараа үнэлүүлсэн түүхэн энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Монгол Улсын Зэвсэгт хүчин улс орныхоо эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах стратегийн бүтээн байгуулалтын ажилд бусдаж ахуйн нэгж, төрийн байгууллагуудтай хамтран нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжлийн болон техникийн өндөр бэлтгэлтэй оролцон, монгол хүн, монголчууд бие даан бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж чаддаг гэдгийг ард түмэндээ батлан харуулж чадсан томоохон бүтээн байгуулалт бол Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын төсөл байлаа.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн төр засгаас даалгасан томоохон төслийг хийж гүйцэтгэсэн нь орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойдоо барьж буй томоохон бэлэг юм.

Энэхүү төслийг гүйцэтгэхэд хамтран ажилласан зам, барилгын салбарын хөгжлийн манлайлагч, үндэсний бүтээн байгуулагч 60 гаруй аж ахуйн нэгжийн удирдлага, инженер, техникийн ажилчид, хамт олон, тэдний гэр бүлд талархал илэрхийлье.

Бид бүхэн "Шинэ төмөр зам" төслийн 416,1 километр төмөр замыг барьж гүйцэтгэснээр нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх олон төсөл хөтөлбөрийн эхлэлийг тавьж чадсан түүхэн гавьяаны эзэд гэдгийг дахин онцолъё" гэлээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

66.443

ЭДГЭРСЭН

54.081

НАС БАРСАН

313/14

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2714 (38)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

266

ЭДГЭРСЭН

2408

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 172,630,637

Эдгэрсэн

Нийт: 150,443,319

Нас барсан

Нийт: 3,718,683



**Хүүхдийг
КОРОНАВИРУСТ
ХАЛДВАР (КОВИД-19)-
ААС СЭРГИЙЛБЭ!**

ЦАХИМ ШУУДАНД

ДУГУЙТАЙ АЛБА ХААГЧИД ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭ СУРТАЛЧЛАВ



Зэвсэгт хүчний 330 дугаар анги

Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 19 жилийн ой, "Олон улсын энхийг сахиулагчдын өдөр"-ийг тохиолдуулан тус ангийн унадаг дугуйн клубийн 50 офицер, ахлагч Дархан-

Уул аймгийн төвөөр тойрч, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэдэд сурталчиллаа. Мөн энэ хүрээнд аймгийн хүүхэд залууст энхийг сахиулагчдын талаарх мэдээлэл түгээсний зэрэгцээ дасгал хөдөлгөөн, дугуй унаснаар хэрхэн эрүүл чийрэг бие бялдартай болох талаар таниулга сурталчилгаа хийв.



НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ БОЛОВ

Зэвсэгт хүчний 017 дугаар анги

Хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөллийг ангийн үйл ажиллагаатай танилцуулах "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгт цар тахлын эсрэг вакцины 1, 2 дугаар тунг хийлгэж 14-өөс дээш хоносон эцэг эх, ар гэрийн төлөөлөл оролцов. Эцэг эхчүүдийг ангийн удирдлага хүлээн авч уулзан мэдээлэл өгч, тэдний сонирхсон асуултад хариулт өглөө. Ар гэрийн төлөөлөл дайчдын алба хааж буй орчин нөхцөлд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, талархал дэвшүүллээ. Тус ангийн ХЦАХ-чид төмөр замын бүтээн байгуулалтад оролцож байгаад ангийн байрлалд ирсэн бөгөөд өдөрлөгийн төгсгөлд Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын даргын талархлын захидлыг эцэг эх, ар гэрийн төлөөлөлд гардуулав.




нарын Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг үзэж сонирхон, Дайчин алдрын танхим, соёл спортын төв, эмнэлэг, халуун ус, цэргийн гал тогооны үйл ажиллагаа болон ангийн байрлалд баригдаж буй цэргийн байрны барилга угсралтын ажлын явцтай танилцлаа.

Ахмад С.УЛАМБАЯР

Мөн тэтгэвэрт гарсан офицер, ахлагч

ЦЭРГИЙН БАЙРНЫ ШАВ ТАВИЛАА

Ангийн өмнө тавигдсан томоохон зорилтуудын нэг болох цэргийн байрны шавь тавих ёслол боллоо. Энэхүү барилга нь 2 давхар 100 цэргийн багтаамжтай бөгөөд энэ намар ашиглалт оруулахаар төлөвлөж байна.



ҮҮРГЭЭ АМЖИЛТТАЙ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА

Ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш манай энхийг сахиулагчид НҮБ-ын мандатаар заагдсан үүргийн дагуу цэргийн багийн хариуцлагын бүс нутагт цагийн байдлыг тогтворжуулах, НҮБ-ын хамгаалалттай Дотоодын дүрвэгсдийн хуарангийн аюулгүй байдлыг хангах, НҮБ-ын ажилтан, албан хаагчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг сахин хамгаалах, баазын харуул, хамгаалалт болон энгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, эргүүл, цувааны хамгаалалтыг зохион байгуулах, цагийн байдлын мэдээ, мэдээлэл олзворлох, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, бүтээн байгуулалтад оролцох зэрэг олон арван ажлыг эв санаа нэгтгэйгээр хийж гүйцэтгэсээр байна.

Бид дэлхий нийтийг хамарсан "Ковид-19" цар тахлын хүндрэлтэй нөхцөлд Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Улсын онгой комисс, ЭМЯ, БХЯ, ЗХЖШ-аас гаргасан заавар зөвлөмжийн хүрээнд бие бүрэлдэхүүний халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан цэргийн сургалт бэлтгэлийг тогтмол зохион

байгуулж, бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшингээ ахиулсаар байгаа билээ.

Үүний тод илрэл нь "Юнити" секторын штабаас улирал тутам явуулдаг бэлэн байдлын шалгалтад цэргийн баг 2 удаа амжилттай шалгуулж, "Үүрэг гүйцэтгэх боломжтой" гэсэн үнэлгээгээ удаа дараа баталгаажуулсан юм.

Энэхүү шалгалтаар цэргийн багийн нийт бие бүрэлдэхүүн болзошгүй цагийн байдалд хэрхэн ажиллах, тасаг, нэгжүүдийн баримт бичгийн боловсруулалт, UNMISS энхийг дэмжих ажиллагааны хүчний командлал болон "Юнити" сектороос ирүүлсэн тушаал шийдвэр, албан даалгаврын хэрэгжилт, "Ковид-19" цар тахлын үед бие бүрэлдэхүүний халдвар, хамгааллын дэглэм хэрхэн мөрдөж байгаа зэрэг олон асуудлыг хөндөж, цэргийн багийн хүний нөөц, тагнуул, ажиллагааны бэлэн байдал, цэргийн алба, харуул хамгаалалт, эргүүл, цувааны үүрэг гүйцэтгэлт, материал, техникийн хангалт, ажиллагааны төлөвлөлт, холбоо мэдээлэл, соёл хүмүүжил, иргэн-цэргийн харилцаа зэрэг чиглэл тус бүрээр шалгаж, үнэллээ.

ХҮҮХДИЙГ "КОВИД-19"-ӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ



Манай улсад одоогийн байдлаар коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж буй 3 хүн тутмын нэг нь хүүхэд байгаа бөгөөд цаашид хүүхдийн өвчлөл нэмэгдэх хандлагатай байгааг ЭМЯ-аас дараах зөвлөмжийг өглөө. Үүнд:

- Хүүхдийг олон нийтийн газраар дагуулж явахгүй байх,
- Айл хэсэхгүй байх,
- Таваас дээш хүүхдийг хамт тоглуулахгүй байх,
- Автомат тоглоомын газарт хүүхдийг тоглуулахгүй байх,
- Хүүхдийг шүлсдэж үнсэхгүй байх,
- Хүүхдийг ам дамжуулан хооллохгүй байх,
- Амны хаалт зүүлгэх,
- Гарыг сайтар савандаж угаалга,
- 1-1,5 метрийн зай барих,
- Хүүхдийн хоолойг сод, давсны уусмалаар ээлжлэн зайлуулах,
- Хүүхдэд А, С, Д амин дэм өгөх,

Хүүхдийг тусад нь аяга тавагтай байлгах, **Сайн унтаж амруулах:**

- 3-5 насныхан 10-13 цаг
- 6-12 насныхан 9-12 цаг
- 12-аас дээш насныхан 8-10 цаг унтаж амрах

- Зөв хооллох:**
- Илчлэг сайтай хоол унд хэрэглэх,
- Жимс, хүнсний ногоо түлхүү хэрэглэх,
- Сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх,
- Чихэрлэг бүтээгдэхүүний хэрэглээг багасгах,
- Халуун бүлээн шингэн ойр ойрхон уулгах,
- Агаар, ус, нараар хүүхдээ чийрэгжүүлэх,
- Хүүхдийн цахим хэрэглээг хязгаарлах,
- Хүүхдийн тоглоомыг сод, давсны уусмалаар угаах цэвэрлэх,
- Хүүхэдтэйгээ ярилцах, таагүй бодол, мэдрэмжийг хуваалцах зэргээр коронавирусын халдвараас сэргийлэхийг зөвлөж байна.

ХҮҮХДЭЭ ЗОРИУЛАЛТЫН СУУДАЛД ТЭЭВЭРЛЭЖ ХЭВШЬЕ

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба

Монгол Улсад сүүлийн 10 жилийн хугацаанд зам тээврийн осолд 10332 хүүхэд өртөж 95.3 хувь буюу 9847 хүүхэд бэртэж гэмтэн хөдөлмөрийн чадвараа их бага хэмжээгээр алдан, 4.7 хувь буюу 485 хүүхэд амиа алдаад байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар зам тээврийн осолд 112 хүүхэд өртөж, 98 хүүхэд бэртэж, 10 хүүхэд амь насаа алдлаа. Иймд алба хаагчид урин дулааны цаг ирсэнтэй холбогдуулан гэр бүлээрээ агаар салхинд гарах, хөдөө орон нутгийн замд зорчихдоо хүүхдээ зориулалтын суудалд тээвэрлэж, замын хөдөлгөөний бусад дүрмийн заалтыг зөрчихгүй байхыг анхааруулж байна.

Дэслэгч Э.ӨНӨБОЛД

<p>СУУДЛЫН БҮС /12 НАСНААС ДЭЭШ, 145CM-ЭЭС ӨНДӨР/</p> <p>Бүсний доод хэсэг нь түүний дөнгүүр гэсэн дэглүүр бий ба босоо байх нь цахилгаан дэглүүр ямар ч аюулгүй байдлыг хангахад хангалттай биш. Суудлын бүсийг зөвхөн зөвхөн хүүхдийн хувцас дотор байрлуулахыг зөвшөөрнө.</p> <p>76 АСУУДАЛ ШИЙДЛЭЛТ</p> <p>#ОРОЛЦ, ШИЙД</p>	<p>ӨНДӨРЛӨГӨӨТЭЙ СУУДАЛ /5-12 НАС/</p> <p>5-наас дээш насны хүүхдэд суудлын бүсийг тохиромжтой байдлаар ашиглах. Хүүхдийн суудлыг зөвхөн нэг агаарын нөхцөлд ашиглахыг зөвшөөрнө. Суудлын бүс тавихгүй үед тусгай өндөрлөгөөтэй суудал ашиглах нь чөлөөтэй байрлуулж болно.</p> <p>76 АСУУДАЛ ШИЙДЛЭЛТ</p> <p>#ОРОЛЦ, ШИЙД</p>
<p>ХҮҮХДИЙН СУУДАЛ /2 НАС ХҮРТЭХ/</p> <p>2 нас хүртэлх буюу өндөр, жингийн хязгаарыг хүртэл ар талын суудалд хойш харуулан суулгана.</p> <p>76 АСУУДАЛ ШИЙДЛЭЛТ</p> <p>#ОРОЛЦ, ШИЙД</p>	<p>ХҮҮХДИЙН СУУДАЛ /2-5 НАС/</p> <p>2-наас дээш насны хүүхдийн суудлыг хойш нь харуулан байрлуулна. Хүүхдийн өндөр сууриас илүү гарсан буюу тухайн үйлдвэрлэлчийн заасан жин, өндрийн хязгаарыг хүртэл буюу өндөрлөгөөтэй 3 нас хүртэл хүүхдийн суудлыг урьдчилан байрлуулна.</p> <p>76 АСУУДАЛ ШИЙДЛЭЛТ</p> <p>#ОРОЛЦ, ШИЙД</p>